



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/356

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд төрийн албаны хурд бүтээмж, цахимжуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор “Цахим Булган гар утасны аппликейшн” хийх гүйцэтгэгчээр шалгарсан “Эйблсофт” ХХК-тай 131,316,522 (нэг зуун гучин нэгэн сая гурван зуун арван зургаан мянга таван зуун хорин хоёр) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Насанжаргалд)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Эйблсофт” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Даваадорж)-д даалгасугай.

3. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу “Цахим Булган хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



8326010468

Аймгийн Засаг даргын 2026 оны
05 дугаар сарын 13-ны/ний өдрийн
А/ЗСБ дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээнд зааснаар	Б.Насанжаргал
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана	Б.Ариунболд
3	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд

--o00o--